

Гэр бүлийн залбирлын адислалууд, гэр бүлээрээ судраас суралцах ба гэр бүлийн үдэш

Сүмийн удирдагчдын заасан дараах сургаалыг уншихдаа, гэр бүлээрээ өдөр тутам залбирч, судруудаас суралцан, долоо хоног бүр гэр бүлийн үдэш хийснээр ирэх адислалуудыг доогуур нь зурж тэмдэглээрэй.



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Ричард Г.Скотт:

“Эцэг эхчүүд ээ, та нар өглөө, оройд хүүхдүүдээ гэр бүлийн залбирлын хүчээр зэвсэглэснээр тэднийг хамгаалахад туслаарай. . . . Гэр бүлийн залбирлын ачаар ирдэг хүчирхэг адислалуудаар дамжуулан хүүхдүүдээ өдөр бүр дэлхийн нөлөөнөөс хамгаалаарай. Гэр бүлийн залбирал өдөр тутмын амьдралд тань ямар ч эргэлзээгүй эн тэргүүний зүйл байх ёстой.

. . . Тэдгээрийг [ариун судруудыг] өдөр тутмынхаа амьдралын салшгүй хэсэг болгоорой. Хэрэв хүүхдүүд тань Сүнсний өдөөлтийг мэдэрч, ойлгож, түүн дээр үйлдэхийг хүсвэл та нар тэдэнтэй хамт судруудаас судлах ёстой. . . . Та нар судруудыг өдөр бүр, тогтмол судалснаар өөрсдийн эргэн тойрон дахь хямрал бухимдал дундаас амар амгалан, уруу таталтыг эсэргүүцэх хүч чадлыг олох болно. Та нар Бурханы ач ивээлээр хүчирхэг итгэлийг хөгжүүлснээр Есүс Христийн цагаатгалаар дамжин бүх зүйл Бурханы цаг хугацааны дагуу зөв болгогдоно гэдгийг мэднэ” гэж заасан (“Итгэлээ ашиглахыг эн тэргүүнд тавь,” *Ensign* эсвэл 2014 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 105–109).



Халамжийн нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн Линда С.Рийвс эгч:

“Би долоо хоног бүр гэр бүлийн үдэш хийж, өдөр тутам судраас суралцаж, залбирснаар ирдэг адислалуудын талаар гэрчлэх ёстой. Эдгээр дадал хэвшил нь сэтгэлийн дарамтыг тайлж, бидний амьдралд удирдамж өгч, гэр орноо илүү бат бэх хамгаалалттай болгоход туслах зуршлууд юм” гэж заажээ (“Христэд төвлөрсөн гэр орон—порнографын эсрэг хамгаалалт,” *Ensign* эсвэл 2014 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 28-31).



Ерөнхийлөгч Томас С.Монсон тунхаглахдаа:

“Гэр бүлийн залбирал нь нүглээс хамгаалах хамгийн том бэхлэлт учраас аз жаргал, баяр баясгалангаар хамгийн ач тустай хангагч юм” гэжээ (“Hallmarks of a Happy Home,” *Ensign*, 1988 оны 11-р сар, 69).

Дараах асуултуудыг эргэцүүлэн бод:

- Та эдгээр адислалаас алийг нь өөрийн гэр бүлд хүлээн авч байсан эсвэл бусад гэр бүлд ирж байхыг харж байсан бэ?
- Та эдгээр адислалыг бүрэн дүүрэн хүлээн авахын тулд одоо юу хийж чадах вэ?